

НИЙСЛЭЛИЙН ҮЙЛДВЭР ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
ХЯНАЛТАД БАЙГАА ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН МЭДЭЭ

2014.12.30

№	Эрх зүйн актын нэр, агуулга, огноо, дугаар:	Заалт	Хяналтанд байгаа заалтыг хэрэгжүүлэх талаар төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө. Гүйцэтгэлийн хувь (%)	Хяналтаас хасах, өөрчлөлт оруулах тухай санал, үндэслэл
1	2010.06.02 № 138 Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний талаар авах зарим арга хэмжээний тухай	4. 2011 оноос эхлэн Улаанбаатар хотод 12.0 мянган тонн, Дархан, Эрдэнэт хотод тус бүр 1.0 мянган тонн, бусад аймгийн төвүүдэд 100 тонноос доошгүй хэмжээний мах нөөцлөн, жил бүрийн хаврын улиралд борлуулах ажлыг зохион байгуулж байхыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	-	-	Хасуулах /2012 оноос Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам нөөцийн махны асуудлыг хариуцаж байгаа/
2		10. Дүүргүүдэд ашиглаж байгаа агропаркийн ашиглалтыг сайжруулан, хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авахыг нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Мэргэжил арга зүйн зөвөлгөө өгч ажиллах	УВ агропарк нь 73 га-д төмс шинээр тариалж нийт 530 гаруй тн ургац хураан авсан. 2014 онд Нийслэлийн тариаланчид төмс 393га талбайд тариалж 5692 тонн, хүнсний ногоо 392 га талбайд тариалж, 6603 тонн ургац хураан авсан нь нийслэлийн хүн амын хүнсний ногооны хангамжийн 8,8%-ийг төмсөөр, 7,3%-ийг хүнсний ногоогоор хангаж ажлын үр дүн 85%тай явж байна.	Хасуулах /УВ агропарк нь Нийслэлийн Хөдөлмөрийн газар хариуцан ажиллаж байгаа/
3		13.Мах, сүү, төмс, хүнсний ногооны нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог зах зээлийн харилцаанд нийцүүлэн боловсронгуй болгох, орчин үеийн төрөлжсөн бөөний худалдааны төв, агуулах байгуулах, энэ төрлийн төслийг гадаадын зээл,	Нийслэлийн 6 дүүрэгт төмс, хүнсний ногоо худалдаалах төвлөрсөн цэгийг зохион байгуулж ажиллах, Бондын санхүүжүүлэлтээр нийслэлд баригдах зоорь агуулахын гүйцэтгэлд хяналт тавин ажиллах,	Монгол улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 96,4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Ерөнхий сайдын 100 дугаар захирамжийн дагуу нийслэлийн Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдэд эх орны хөрсөнд ургасан дотоодын төмс, хүнсний ногоо, жимс	-

		<p>тусламжид хамруулах ажлыг үе шаттай зохион байгуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт тус тус даалгасугай.</p>		<p>жимсгэний борлуулалт хийх зөвшөөрөл бүхий 5 дүүрэгт 19 павилон, төвлөрсөн 5 асарт хөдөө орон нутгуудаас болон нийслэлийн ногоочид, бүлэг хоршоодоос оролцох, ногоочдын борлуулалтыг 08 сарын 15-11 дүгээр сарын 1 хүртэл дэмжих ажлыг ҮХААЯам, Нийслэлийн Үйлдвэр, Хөдөө Аж ахуйн газар, Сэлэнгийн төлөө хөгжилийн сан, Монголын Хөдөөг Шинэчлэхийн Төлөө Фермерүүдийн Холбоо, Хүнс Хөдөө Аж Ахуйн Ассоциаци зэрэг Төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж ажиллалаа.</p> <p>“Нийслэлийн дүүргүүдэд төмс хүнсний ногоо, жимс, жимсгэнэ борлуулах” үзэсгэлэн худалдаанд 10 аймаг, нийслэлийн 5 дүүргийн нийт 8 аж ахуй нэгж, 8 хоршоо, 4 төсөл, 300 гаруй ногоочин оролцож, 133.18 тонн төмс, 202.1 тн хүнсний ногоо худалдаж, нийт 268,228,800 төгрөгний борлуулалт, зөгийн бал 1.9 тн-ыг худалдаж 39,06 сая төгрөгний борлуулалт, жимс, жимсгэнэ 568 кг-ыг худалдаж 4,5 сая төгрөгний борлуулалт тус тус хийгдэж 100%- ийн биелэлттэй явагдаж байна.</p> <p>2. Монгол банкинд хүргүүлсэн эхний 33 төслөөр зоорийн багтаамж нийт 92,0 мянган тонноор нэмэгсэн байна. Автомат, хагас автомат удирдлагатай, иж бүрэн механикжсан ажиллагаатай төмс, хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүний зоорь, агуулах худалдааны төвүүдийг байгуулах боломжийг бүрдүүлж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Төмс, хүнсний ногооны зоорь 66,5 мянган тонноор • Мах махан бүтээгдэхүүний хөргүүртэй зоорь, худалдааны
--	--	--	--	---

				<p>төвийн багтаамж 25,5 мянган тонноор тус тус нэмэгдсээр байна.</p> <p>Төмс, хүнсний ногооны зоорийн багтаамж 37 хувиар нэмэгдэж 248,7 мянган тоннд хүрч жилдээ хураан авах төмс, хүнсний ногооны зоорийн хангамж 71,0 хувьд нийт ажлын хүрээнд 90%- тай байна.</p>	
4	<p>2013.12.14 №411 Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам батлах тухай</p>	<p>2. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль болон энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулж мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, бүх шатны төсөвт байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай.</p>	<p>Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий журмыг албан хаагчдад мөрдүүлнэ. Байгууллагын цахим хуудсыг шинэчилнэ.</p>	<p>Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ерөнхий журмыг албан хаагчдад танилцуулж, мөрдлөг болгосон Байгууллагын цахим хуудсыг шинэчлэн, өдөр тутам мэдээ мэдээллээр баяжуулан ажиллаж байна. Цахим шуудан болон дэлгэцээр цаг үеийн мэдээ, мэдээлэл, зөвлөмж, танилцуулга, шаардлагатай мэдээллүүдийг явуулж байна. “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагаас иргэд, хуулийн этгээдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд “UBLEGAL.MN” цахим хуудсанд 1993-2013 онд байгууллагаас гарсан захирамжлын баримт бичгийг орууллаа. /100%/</p>	-
5	<p>2014.05.10 №147 Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай</p>	<p>1.1) Чиг үүргийн давхардалтай эсхүл нэг төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагчийн харьяанд байгаа чиг үүрэг ойролцоо, харилцан уялдаа бүхий үйл ажиллагаа гүйцэтгэж байгаа төсөвт байгууллагуудыг нэгтгэн зохион байгуулах замаар удирдлагын зардлыг бууруулах;</p>	-	-	<p>Хасуулах. /Манай байгууллагын эрхлэх хүрээний асуудал биш/</p>

6		1.4) Төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах үүрэгтэй харуул хамгаалалт, халаалт дулаан, цэвэрлэгээ зэрэг үйлчилгээг гэрээний үндсэн дээр хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх, төрийн албаны гэрээт ажилтны орон тоог 50 хувиар бууруулах санал боловсруулж шийдвэрлүүлэх;	-	-	Хасуулах. /Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газраас байгууллагын үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж байгаа/
7		3.1) Төсвийн санхүүжилтийг бууруулснаар өр, авлага үүсгэхгүйгээр зардал хэмнэх боломжийг дайчлах;	-	Өр, авлага үүсгэхгүйгээр ажилласан. 100%	-
8		3.2) Улсын төсвийн татаас, орон нутгийн төсвийн урсгал зардлыг 20-иос доошгүй хувиар бууруулах;	-	Журмын дагуу урсгал зардлыг хэмнэж ажиллаж байна	-
9		3.3) Шинээр орон тоо нэмэгдүүлэхгүй байх, ажлын байрны ачааллыг нягтруулж орон тоог бууруулах, сул чөлөөтэй орон тоонд томилгоо хийхгүй байх замаар цалингийн зардлыг хэмнэх;		Газрын хэмжээнд ИТ, компьютерийн мэргэжилтэн зайлшгүй шаардлагатай учраас Техник тоног төхөөрөмж, усан хангамж хариуцсан мэргэжилтнүүдийн ажлыг нэгтгэж, Захиргааны хэлтэст Мэдээллийн технологи, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэний ажлын байрыг бий болгож, ажлын байрны тодорхойлолтыг шинээр боловсрууллаа. Манай байгууллагын захиалгаар ХАА эрхэлсэн орлогч даргын албан тушаал дээр 2014 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулсан Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт явуулсан боловч Монгол Улсын Засгийн газрын “Төсвийг	

				<p>хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолын 1.3, 3.3 дугаар заалтууд, Нийслэлийн Засаг даргаас 2014 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 2а/1924 дүгээр албан бичгээр өгсөн үүрэг даалгаврын дагуу орлогч даргын албан тушаал болон Захиргааны хэлтэст Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилгоо хийгээгүй байна.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 147 дугаар тогтоолын дагуу ажлын байрыг оновчтой болгох саналыг боловсрууллаа.</p>	
10		3.4) “Суудлын автомашины талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2007 оны 349 дүгээр тогтоолоор тогтоосон албан тушаалын болон албан ажлын автомашины хэрэглээний зардлыг 20 хүртэл хувиар хэмнэх;	-	албан тушаалын болон албан ажлын автомашины хэрэглээний зардлыг 20 хүртэл хувиар хэмнэх ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн автомашин ашиглалтын хувиар гарган ажиллаж байна	-
11		3.5) Гадаад албан томилолтын зардлыг бууруулах, зайлшгүй тохиолдолд зорчих төлөөлөгчийн тоог цөөлөх, төсвийн хөрөнгөөр бизнес ангиллын нислэгээр зорчихгүй байх;	-	-	Хасуулах. /Гадаад томилолтын зардал байхгүй/
12		3.6) Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор	-	Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр, ялангуяа төсвийн нэмэлт орлого, хандив болон тусламжийн орлогоор гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн	-

		гадаад, дотоодын тойрон аялал, зугаалга, ой тэмдэглэх арга хэмжээ, урлагийн наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байх;		наадам, уралдаан тэмцээн зохион байгуулахгүй байхыг Газрын дарга үүрэг болгосон. 100%	
13		3.7) Хурал, сургалт, зөвлөгөөний давтамжийг багасгах, зайлшгүй хийх тохиолдолд төлөөлөгчдийн тоог цөөн, оновчтой, богино хугацаанд хийхээр эсхүл цахим хэлбэрээр зохион байгуулах;	Хурал, сургалт зөвлөгөөний төлөвлөгөө дахин төлөвлөх, Богино хугацааны хурал, сургалт, зөвлөгөөг цахим хэлбэрээр явуулах,	Хэлтсүүдээс явуулдаг сургалтын төлөвлөгөөг нэгтгэн гаргаж, бусад байгууллагатай хамтран зохион байгуулж байна. Албан хаагчдын хууль эрх зүйн, ёс зүйн мэдлэг олгох сургалтыг мэдээллийг цахим шуудангаар хүргэж ажиллаж байна. /100%/	-
14		3.8) Төрөөс иргэд, аж ахуйн нэгж, хувийн хэвшилд үзүүлж буй үйлчилгээг цахим технологи, сүлжээ ашиглан чирэгдэлгүй хурдан, шуурхай хүргэх замаар төсвийн урсгал зардлыг бууруулах, энэ чиглэлээр шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;	Иргэдэд үзүүлж буй төрийн цахим хуудсаар дамжуулан ил тод, шуурхай хүргэх Цахим хуудсан Төрийн үйлчилгээ гэсэн шинэ цэц үүсгэн мэдээллээр хангаж ажиллах.	Манай байгууллагаас иргэдэд үзүүлдэг төрийн 12 үйлчилгээг цахим хуудсанд шинэ цэц үүсгэн мэдээллийг байршуулан иргэд шуурхай мэдээлэн ажиллаж байна. /100%/	-
15		3.9) Орон нутгийн байгаль, цаг уурын нөхцөлд нийцүүлж спорт заал, соёлын төв зэрэг төсөвт байгууллагын барилга байгууламжийг төвлөрсөн дулааны системд холбох, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан халаалт зэрэг бусад үр ашигтай арга, технологи нэвтрүүлэх замаар түлш, халаалтын зардал хэмнэх, цаашид ийм төрлийн зардлыг тогтмол түвшингээр	-	-	Хасуулах. /Объект байхгүй/

		төсөвлөх, улмаар үе шаттай бууруулах;			
16		4. Яам, агентлаг, төсөвт байгууллагууд төв, орон нутгийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан төсвийн хөрөнгөөр олон нийтэд зайлшгүй мэдээлэх хууль тогтоомж, албан ёсны шийдвэр болон тэдгээрийн хэрэгжилтийг сурталчлан таниулахаас бусад зорилгоор өөрийн байгууллага, хамт олныг рекламдах, телевизийн шоу уралдаан, тэмцээн зохион байгуулах, цуврал олон ангит кино хийхгүй бөгөөд баяр ёслол, байгууллага, салбарын ой, тэмдэглэлт өдөр зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, ивээн тэтгэхийг хориглосугай.		УИХ-ын дарга З.Энхболдын санаачилсан цаасан мэндчилгээг цахим болгох уриалгыг дэмжин харилцагч байгууллага, аж ахуйн нэгжид баярын мэндчилгээг цахим хэлбэрээр хүргэх ажлыг хэвшүүлээ. Мөн тэмдэглэлт баяр ёслолыг байгууллагын хөрөнгөөр зохион байгуулахгүй байхыг Газрын дарга үүрэг болгосон. 100%	-
	2014.07.28 №241 Хөдөө аж ахуйн салбарын 2014-2015 оны өвөлжилтийн бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай	2.1. Мал аж ахуйн салбарын 2014-2015 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг төлөвлөгөө гарган зохион байгуулж, биелэлтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг тухай бүрт нь шуурхай шийдвэрлэж ажиллах;	Нийслэлийн засаг даргын 04 албан даалгаврыг дүүргүүдэд хүргүүлж, төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөмж хүргүүллээ.	Албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 8 зорилт 21 заалтаар боловсруулж хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг бүрэн хангуулах зорилгоор Засгийн газрын 2014 оны 241 дүгээр тогтоол, Үйлдвэр хөдөө аж ахуйн яамны сайдын 01 албан даалгавар, Нийслэлийн засаг даргын 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтэнд хяналт тавьж	-

				<p>өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг хангасан байдалтай газар дээр нь очиж танилцаж үнэлэлт, дүгнэлт өгч ажиллалаа. Нийслэлийн хэмжээнд мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл бүрэн хангагдсан байна. /100%/</p>	
		<p>2.2.Малчид, иргэд, аж ахуйн нэгжийн хадпан, тэжээл бэлтгэх техник, тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллаж аймаг, нийслэл, сум, дүүргийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг заавал бүрдүүлэх;</p>		<p>Нийслэлийн 7 дүүрэгт 10 аж ахуйн нэгж малын тэжээлийн үйлдвэрлэл явуулж байна. Үүнээс 5 аж ахуйн нэгж тэжээл тариалах талбайтай бөгөөд 8419,0 тн тэжээл үйлдвэрлэж хэрэглэгчдэд нийлүүлсэн байна. “Алтан тариа” ХХК үхэр, адуу, гахай, тахианы бүрэн найрлагат тэжээл хоногт 200 тонныг үйлдвэрлэж хэрэглэгчдэд нийлүүлсэн дүн мэдээтэй байна.</p> <p>Мөн тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх чиглэлээр Нийслэлийн “Монгол мал” дэд хөтөлбөрт тодорхой асуудлыг тусган ажиллаж байна.</p> <p>Мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн 6 дүүргийн хэмжээнд аюулгүйн нөөцийг бүрдүүлэн ажиллаж Багануур дүүрэг 153.7 тонн өвс, Налайх дүүрэг 30 тн тэжээл бэлтгэн, агуулахад нөөцөлсөн байна.</p> <p>Хан-уул дүүрэг 54 сая, Баянзүрх дүүрэг 36 сая төгрөгийг засаг даргын нөөц хөрөнгөнд тусгасан бөгөөд Багахангай дүүрэг аюулгүйн нөөцийг хандиваар бүрдүүлэх талаар дүүргийн засаг даргын албан даалгаварт тусган тодорхой хэмжээний төсвийг бүрдүүлсэн байна.</p> <p>Цаг агаар хүндэрсэн, болзошгүй үед аюулгүйн нөөцөд хэрэглэхээр санхүүгийн эх үүсвэрийг дүүрэг бүрт бүрдүүлэн ажиллалаа. /100%/</p>	-
		<p>2.7.Улсын төсвийн болон төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгөөр шинээр худаг</p>	<p>2014 оны төсөвт бэлчээр усан хангамжийг гаргах, худгийн төсөвт санал</p>	<p>Улсын төсвийн хөрөнгөөр нийслэлийн нутаг дэвсгэрт 10 ширхэг инженерийн хийцтэй гүн өрмийн худгийн тендерт</p>	-

		гаргах, бэлчээрийн хортон мэрэгч, шавжтай тэмцэх ажлын явцад хийх гүйцэтгэлийн хяналт, шалгалтыг сайжруулах;	оруулах Нийслэлийн Засаг Даргын захирамжийн хэрэгжилтийг зохион байгуулах	“Монтегео” ХХК 160998383 төгрөгний ажил гүйцэтгэгчээр шалгарч 2014 оны 09 дүгээр сарын 29-нд Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 3 дугаар хавсралтын гуравдугаар ангилалд заагдсан бүрэлдэхүүнээр хүлээн авсан. Доорх байршилуудад 10 ширхэг гүн өрмийн худаг шинээр гаргаж, орон нутагт нь хүлээлгэн өгснөөр 50 гаруй өрхийн 20000 малын бэлчээрийн усан хангамжийг хангах нөхцөл бололцоог бүрдүүллээ. Энэ жилийн ургалтын хугацаанд цаг уурын хувьд хүйтэвтэр бороо хуртай байсан тул бэлчээрийн хортон мэрэгч шавьж илрээгүй тул хяналт шалгалт хийгдээгүй. /100%/	
		2.8. Малчин өрх бүрээр малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлш, өвлийн хувцсаа бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээл бэлтгэн нөөцлөх зэргээр мал өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулах;		Нийслэлийн хэмжээнд 7856,5 тонн өвс хадлан, 1962 тонн давс хужир, 432 тн гар тэжээл бэлтгэсэн дүн мэдээтэй байна. Нийслэлийн хэмжээнд шинээр 22 худаг гаргасан бөгөөд үүнээс малчдын санаачлагаар 5, гадаадын төсөл хөтөлбөрөөр 2, улсын төсвөөр 10, орон нутаг өөрийн хөрөнгөөр 5 худаг тус тус гаргасан байна. Сонгинохайрхан, Хан-Уул, Багахангай, Налайх дүүргийн 89 өрхийн 11,1 толгой мал өөр аймгийн нутагт өвөлжихөөс бод мал 3552 толгой, бог мал 7585 толгой байна. Үүнээс гадна отроор өөр аймгийн нутагт өвөлжих малчдын хувийн бэлтгэл хашаа хорооны засвар, түлээ түлш, хувцас хэрэгслийг хангуулах талаар орон нутгийн удирдлагууд боломжит арга хэмжээг авч ажиллаж байна. /100%/	-
2014.09.18 №291	2.Улсын нэгдсэн төсвийн хэрэгжилтийг хангах			Төсвийн санхүүжилтийн хүрээнд өр төлбөр үүсгэхгүй ажиллаж нийт	

	<p>Монгол Улсын 2014 оны төсвийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай</p>	<p>зорилгоор төсвийн бүх шатны эрх захирагч нарт даалгасугай: 2.1.Төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан олгосон санхүүжилтийн хүрээнд үйл ажиллагаагаа оновчтой зохион байгуулж, төсвийн сахилга хариуцлагыг өндөржүүлж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах;</p>		<p>71,348,500 төгрөгийг хэмнэж ажилласан.</p>	
		<p>2.2.Улс орон нутгийн төсвийн урсгал болон хөрөнгийн зардлаар 9 дүгээр сарын 19-нөөс хойш хийгдсэн худалдан авахаар төлөвлөсөн бараа, ажил, үйлчилгээний тендер зарлах, дүгнэх, гэрээ байгуулах ажлын санхүүжилтийг энэ оны төсвөөс санхүүжүүлэхгүй байх, ирэх оны төсвийн, төсөлд тусган хэрэгжүүлэх бэлтгэлийг хангаж ажиллах</p>	-	<p>Улс орон нутгийн төсвийн урсгал болон хөрөнгийн зардлаар 9 дүгээр сарын 19-нөөс хойш худалдан авалт, тендер зарлах зэрэг ажлууд хийгдээгүй болно.</p>	-

ХЯНАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Д.МЯГМАРСҮРЭН

БИЕЛЭЛТ ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Б.САЙНБАЯР